



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 662

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалт, Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн орон нутгийн төсвийн санхүүжилтээр бий болсон, нийт 488,333,800.00 (дөрвөн зуун наян найман сая гурван зуун гучин гурван мянга найман зуун) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Гадаадын иргэн, харьяатын газар (Дорноговь аймаг дахь газар)-ын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Мөнх-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006944
34-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн
62 дугаар тогтоолын хавсралт



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР
БИЙ БОЛСОН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР (ДОРНОГОВЬ АЙМАГ
ДАХЬ ГАЗАР)-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо шир хэг	Нийт үнэ (төгрөг)
1. Автомашин				
1	Тоёота приус-30, 31-54 УАМ	24,450,000.00	1	24,450,000.00
2	Тоёота приус-30, 41-27 УБО	24,450,000.00	1	24,450,000.00
3	Хьюндай соната, DN8, 51-24 УБС	99,800,000.00	1	99,800,000.00
Нийт дүн				148,700,000.00
2. Машин тоног төхөөрөмж				
1	Ipad	2,420,000.00	5	12,100,000.00
2	Принтер (өнгөт Epson R1390)	1,760,000.00	3	5,280,000.00
3	Суурин компьютер (I5 Dell)	2,860,000.00	11	31,460,000.00
4	Зөөврийн компьютер (dell I7)	2,640,000.00	8	21,120,000.00
5	Дрон (Phantom 4 pro)	7,150,000.00	1	7,150,000.00
6	Ухаалаг самбар	7,700,000.00	1	7,700,000.00
7	Проектор	1,760,000.00	1	1,760,000.00
8	Олон үйлдэлт принтер	715,000.00	10	7,150,000.00
9	Хяналтын камер (IP)	385,000.00	20	7,700,000.00
10	Бичигч төхөөрөмж	550,000.00	5	2,750,000.00
11	Оффис тоос сорогч	1,650,000.00	2	3,300,000.00
12	Хагас автомат угаалгын машин	1,980,000.00	1	1,980,000.00
13	Дунд оврын тасалгааны халаагч	1,320,000.00	4	5,280,000.00
14	Электрон онооны самбар	3,850,000.00	1	3,850,000.00
15	Зөөврийн acer notebook	3,080,000.00	10	30,800,000.00
16	Суурин компьютер	2,590,500.00	21	54,400,500.00
17	Скайнер	1,109,900.00	7	7,769,300.00
18	Принтер (олон үйлдэлт)	482,900.00	10	4,829,000.00
Нийт дүн				216,378,800.00
3. Тавилга, эд хогшил				
1	Ширээ (Дарга, хурлын өрөөний)	1,320,000.00	1	1,320,000.00

2	Бичгийн шүүгээ	1,100,000.00	10	11,000,000.00
3	Бичгийн ширээ	1,320,000.00	10	13,200,000.00
4	Сандал (дарга)	715,000.00	12	8,580,000.00
5	Сэтгүүлийн ширээ	880,000.00	3	2,640,000.00
6	Агуулахын тавиур	385,000.00	5	1,925,000.00
7	Архивын цахим баримт хадгалах шүүгээ	770,000.00	2	1,540,000.00
8	Хүндрүүлэгчтэй сейф	1,430,000.00	25	35,750,000.00
9	Агуулахын өлгүүр	440,000.00	3	1,320,000.00
10	Уулзалтын ширээ	1,650,000.00	1	1,650,000.00
11	Буйдан (ком)	495,000.00	2	990,000.00
12	Сандал (дугуйгүй түшлэгтэй)	330,000.00	40	13,200,000.00
13	Сандал (дугуйгүй сеткен артай)	220,000.00	10	2,200,000.00
14	Сандал (дарга дугуйтай сеткен)	660,000.00	1	660,000.00
15	Ширээ (дарга бор саарал)	3,000,000.00	1	3,000,000.00
16	Ширээ (хурлын бор саарал)	2,500,000.00	1	2,500,000.00
17	Шкаф (ханын тавиур шүүгээтэй)	2,530,000.00	1	2,530,000.00
18	Ширээ (тумботой шаргал)	660,000.00	10	6,600,000.00
19	Шүүгээ (хувцасны шаргал)	880,000.00	5	4,400,000.00
20	Шүүгээ (номын дээд тал нь шилэн хаалгатай шаргал)	1,650,000.00	5	8,250,000.00
	Нийт дүн			123,255,000.00
41	Бүгд дүн			488,333,800.00